

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Мандал сумын Нэгдсэн эмнэлгийн 2024 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2025/167/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn www.open.audit.mn Сүхбаатар сум 2025 он	Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас: 7036-3040 Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn Аудитын менежер: Б.Батмөнх Утас: 7036-3036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn Аудитор: О.Анхбаяр Утас: 7036-2442 Цахим хаяг: ankhbayaro@audit.gov.mn
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. АУДИТЫН ДҮГНЭЛТ	3
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	12
4. АУДИТЫН ТАЙЛАН	16
4.1 Ерөнхий зүйл	16
4.2 Материаллаг байдал	17
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	17
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	17
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	18
4.5.1 Завсрын аудитын талаар	18
4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн	18
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	18
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	19
5.1 Төлбөрийн акт	19
5.2 Албан шаардлага	20
5.3 Зөвлөмж	20
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	22

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ЗГНХ	Засгийн газрын нөөц хөрөнгө
ЗДНХ	Засаг даргын нөөц хөрөнгө
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
НТШ	Нээлттэй тендер шалгаруулалт
НҮТББ	Нийгэмд үйлчилдэг төрийн үйлчилгээний байгууллага
ТБОНӨХБАУХАТ	Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ЭМДЕГ	Эрүүл мэндийн даатгалын Ерөнхий газар
ЭМДС	Эрүүл мэндийн даатгалын сан
ЭМДҮЗ	Эрүүл мэндийн даатгалын Үндэсний зөвлөл
ЭМЯ	Эрүүл мэндийн яам



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

СЭЛЭНГЭ АЙМГИЙН МАНДАЛ
СУМЫН НЭГДСЭН ЭМНЭЛГИЙН
ДАРГА Ё.БУЯНДЭЛГЭР ТАНАА

2025. 12. 25 № 08А-2025/167/АА-СТА-ТМЗ
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Мандал сумын Нэгдсэн эмнэлгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд ЭМЯ, Азийн хөгжлийн банк, аймгийн ЗДТГ зэрэг байгууллагуудаас **921,221.4** мянган төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авч хөрөнгөд бүртгэсэн байна.

Засгийн газрын 2024 оны 128 дугаар тогтоолоор төрийн албаны зарим албан тушаалын цалингийн сүлжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 6 дугаар хавсралтаар баталсан “Төрийн захиргааны, үйлчилгээний болон улс төрийн албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчид орон нутгийн нэмэгдэл олгох журам”-аар тайлант оны 4 сараас эхлэн орон нутгийн нэмэгдэл авсан зэргээс шалтгаалж тус газрын 2024 оны цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардал өмнөх оноос 37.5 хувиар нэмэгдсэн

432502063

бөгөөд урсгал зардлын 64.7 хувийг цалин хөлс, нэмэгдэл урамшил болон ажил олгогчоос төлөх эрүүл мэндийн даатгалын зардал эзэлж байна.

Аудитын гол асуудал

Тус эмнэлэг нь байгууллагын даргын 2019 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 175 дугаар тушаалаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөж байгаа нь гүйцэтгэлээр санхүүжиж байгаа эрүүл мэндийн байгууллагын онцлогт нийцэхгүй, тухайн цаг үеэс хойш нягтлан бодох бүртгэлтэй холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам зэрэг хууль эрх зүйн актуудад орсон өөрчлөлтүүд мөрдөгдөхгүй байх эрсдэлийг үүсгэж байна.

Бусад асуудлын хэсэг

Сэлэнгэ аймгийн Мандал сумын Нэгдсэн эмнэлэг нь 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан 2 зорилтын хүрээнд 60 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 99 хувийн гүйцэтгэлтэй үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	748,479,253.10	1,719,604,993.38
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	1,006,760.09	41,340,252.28
31200	Банканд байгаа бэлэн мөнгө	1,006,760.09	41,340,252.28
31210	Төгрөг	1,006,760.09	41,340,252.28
31211	Төрийн сангийн харилцах	1,006,760.09	41,340,252.28
33	АВЛАГА	301,744,449.00	1,232,836,826.11
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	301,744,449.00	1,229,706,908.11
33500	Бусад авлага	0.00	3,129,918.00
33510	Байгууллагаас авах авлага	0.00	3,129,918.00
35	БАРАА МАТЕРИАЛ	445,728,044.01	445,427,914.99
35100	Түүхий эд материал	274,049,487.74	229,082,949.25
35130	Эм боох материал	274,049,487.74	229,082,949.25
35400	Хангамжийн материал	131,027,009.27	177,178,618.74
35410	Бичиг хэргийн материал	0.00	225,000.00
35420	Аж ахуйн материал	80,463,845.40	75,119,761.40
35440	Түлш, шатах тослох материал	895,000.00	0.00
35450	Барилгын засварын материал	45,768,411.87	92,280,707.34
35460	Хүнсний материал	2,623,332.00	2,706,300.00
35470	Бусад хангамжийн материал	1,276,420.00	6,846,850.00
35600	Мал амьтад	40,651,547.00	39,166,347.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	5,683,069,150.31	5,788,716,535.46
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	5,683,069,150.31	5,788,716,535.46
39200	Биет хөрөнгө	5,574,354,317.06	5,679,757,702.25
39201	Барилга, байгууламж, орон сууц	3,703,255,868.35	3,711,578,570.23
39202	Хуримтлагдсан элэгдэл	-678,973,202.90	-797,354,323.08
39203	Авто-тээврийн хэрэгсэл	312,442,355.52	515,321,355.52
39204	Хуримтлагдсан элэгдэл	-179,479,416.72	-198,545,272.36
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	3,376,377,817.16	3,869,461,423.90
39206	Хуримтлагдсан элэгдэл	-1,098,081,325.24	-1,569,229,686.47
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	188,881,558.57	197,069,008.32
39208	Хуримтлагдсан элэгдэл	-69,688,446.67	-83,590,466.53
39209	Зам, гүүрний байгууламж	29,917,849.95	44,301,697.96
39210	Хуримтлагдсан элэгдэл	-10,868,640.96	-9,824,505.24
39214	Бусад үндсэн хөрөнгө	569,900.00	569,900.00
39300	Биет бус хөрөнгө	108,714,833.25	108,958,833.21
39301	Программ хангамж	258,000.00	330,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-179,166.75	-7,166.79
39303	Бусад биет бус хөрөнгө	108,636,000.00	108,636,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	6,431,548,403.41	7,508,321,528.84
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	667,124,023.17	80,898,446.93
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	667,124,023.17	80,898,446.93
41300	Өглөг	667,124,023.17	80,898,446.93
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	93,205,513.09	0.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	468,384,888.08	60,413,346.93
41360	Бусад өглөг	105,533,622.00	20,485,100.00
41361	Байгууллагад төлөх өглөг	105,533,622.00	20,485,100.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	5,764,424,380.24	7,427,423,081.91
51	Засгийн газрын хувь оролцоо	5,764,424,380.24	7,427,423,081.91
51100	Засгийн газрын оруулсан капитал	1,347,393,178.65	1,347,393,178.65

511001	Улсын төсвийн оруулсан хөрөнгө	1,347,393,178.65	1,347,393,178.65
51200	Хуримтлагдсан үр дүн	1,661,025,644.61	3,364,298,249.25
51210	Өмнөх үеийн үр дүн	471,716,550.11	1,701,299,547.58
51220	Тайлант үеийн үр дүн	1,189,309,094.50	1,662,998,701.67
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,756,005,556.98	2,715,731,654.01
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	6,431,548,403.41	7,508,321,528.84

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	9,239,897,773.08	11,620,438,457.70
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,922,268,684.08	1,143,440,345.61
120	Нийтлэг татварын бус орлого	1,922,268,684.08	1,143,440,345.61
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	178,891,790.51	187,843,260.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	172,974,690.51	172,072,548.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,917,100.00	15,770,712.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	1,686,790,927.04	921,221,405.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	56,585,966.53	45,275,680.61
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	7,317,629,089.00	10,466,098,112.09
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	0.00	569,906,884.29
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	0.00	569,906,884.29
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	7,317,629,089.00	9,896,191,227.80
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	7,317,629,089.00	9,896,191,227.80
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	8,050,588,678.58	9,957,439,756.03
21	УРСГАЛ ЗАРДАЛ	8,050,588,678.58	9,957,439,756.03
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	8,045,663,678.58	9,950,939,756.03
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	4,147,154,782.77	5,504,630,881.38
210101	Үндсэн цалин	2,390,283,282.63	2,760,622,428.40
210102	Нэмэгдэл	1,380,109,823.81	2,209,668,803.07
210103	Унаа хоолны хөнгөлөлт	113,825,811.45	167,825,885.74
210104	Урамшуулал	262,935,864.88	366,513,764.17
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	516,011,588.11	690,340,604.54
210201	Тэтгэврийн даатгал	356,587,988.11	478,568,655.76
210202	Тэтгэмжийн даатгал	39,855,900.00	55,990,277.66
210203	ҮОМШӨ-ний даатгал	31,884,700.00	28,979,400.00
210204	Ажилгүйдлийн даатгал	7,971,200.00	15,912,244.51
210205	Эрүүл мэндийн даатгал	79,711,800.00	110,890,026.61
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	600,055,078.49	556,465,260.03
210301	Гэрэл, цахилгаан	113,787,858.50	99,272,552.09
210302	Түлш, халаалт	371,114,917.99	338,657,814.58
210303	Цэвэр, бохир ус	115,152,302.00	118,534,893.36
2104	Хангамж, бараа материалын зардал	133,413,438.73	159,224,499.13
210401	Бичиг хэрэг	17,236,140.00	14,251,640.00
210402	Тээвэр, шатахуун	63,362,491.00	55,483,052.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,762,997.73	8,670,781.80

210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	10,106,900.00	6,335,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	36,944,910.00	50,862,941.33
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	0.00	23,621,084.00
2105	Нормативт зардал	1,673,760,807.14	1,926,531,876.10
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,479,318,109.14	1,705,821,244.10
210502	Хоол, хүнс	194,442,698.00	220,710,632.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	90,878,320.00	89,756,670.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	36,250,300.00	6,665,000.00
210602	Тавилга	1,672,000.00	0.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	0.00	600,000.00
210604	Урсгал засвар	52,956,020.00	82,491,670.00
2107	Томилолт, зочны зардал	7,353,500.00	6,687,140.00
210702	Дотоод албан томилолт	7,353,500.00	6,687,140.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	286,974,812.00	134,711,505.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	277,862,450.00	123,959,140.00
210803	Даатгалын үйлчилгээ	404,025.00	2,818,450.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,466,588.00	1,091,777.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	6,313,700.00	4,211,000.00
210807	Газрын төлбөр	928,049.00	665,138.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	0.00	1,966,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	590,061,351.34	882,591,319.85
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	8,629,300.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	590,061,351.34	873,962,019.85
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,925,000.00	6,500,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	4,925,000.00	6,500,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,925,000.00	6,500,000.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	1,189,309,094.50	1,662,998,701.67
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	1,189,309,094.50	1,662,998,701.67

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	7,194,776,430.51	9,725,978,912.98
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	178,891,790.51	187,843,260.00
120	Нийтлэг татварын бус орлого	178,891,790.51	187,843,260.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	178,891,790.51	176,943,260.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	172,974,690.51	172,072,548.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,917,100.00	4,870,712.00
120009	Бусад орлого	0.00	10,900,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	7,015,884,640.00	9,538,135,652.98
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	0.00	569,906,884.29
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	0.00	569,906,884.29
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	7,015,884,640.00	8,968,228,768.69
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	7,015,884,640.00	8,968,228,768.69
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	7,054,440,937.05	9,627,257,420.79
21	УРСГАЛ ЗАРДАЛ	7,054,440,937.05	9,627,257,420.79

210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	7,049,515,937.05	9,620,757,420.79
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	4,072,328,557.79	5,597,836,394.47
210101	Үндсэн цалин	2,342,999,226.65	2,808,202,641.49
210102	Нэмэгдэл	1,380,109,823.81	2,255,294,103.07
210103	Унаа хоолны хөнгөлөлт	113,825,811.45	167,825,885.74
210104	Урамшуулал	235,393,695.88	366,513,764.17
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	497,632,300.00	690,340,604.54
210201	Тэтгэврийн даатгал	338,208,700.00	478,568,655.76
210202	Тэтгэмжийн даатгал	39,855,900.00	55,990,277.66
210203	ҮОМШӨ-ний даатгал	31,884,700.00	28,979,400.00
210204	Ажилгүйдлийн даатгал	7,971,200.00	15,912,244.51
210205	Эрүүл мэндийн даатгал	79,711,800.00	110,890,026.61
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	538,033,397.48	618,906,941.04
210301	Гэрэл, цахилгаан	100,473,673.21	112,586,737.38
210302	Түлш, халаалт	329,020,971.27	381,171,761.30
210303	Цэвэр, бохир ус	108,538,753.00	125,148,442.36
2104	Хангамж, бараа материалын зардал	134,041,575.73	147,230,891.80
210401	Бичиг хэрэг	13,269,620.00	15,074,140.00
210402	Тээвэр, шатахуун	65,470,978.00	58,294,220.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,762,997.73	8,085,281.80
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	5,365,000.00	6,295,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	44,172,980.00	59,482,250.00
2105	Нормативт зардал	1,462,687,769.05	2,199,798,321.94
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,259,107,614.05	1,958,189,821.94
210502	Хоол, хүнс	189,668,155.00	236,741,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	13,912,000.00	4,867,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	58,662,150.00	115,509,847.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	8,173,000.00	35,689,817.00
210602	Тавилга	0.00	1,672,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	0.00	600,000.00
210604	Урсгал засвар	50,489,150.00	77,548,030.00
2107	Томилолт, зочны зардал	6,515,800.00	8,669,240.00
210702	Дотоод албан томилолт	6,515,800.00	8,669,240.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	279,614,387.00	225,798,280.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	269,407,750.00	208,253,390.00
210803	Даатгалын үйлчилгээ	0.00	3,222,475.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,466,588.00	1,091,777.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	5,357,000.00	7,770,000.00
210807	Газрын төлбөр	928,049.00	665,138.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	2,455,000.00	4,795,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	16,666,900.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	16,666,900.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,925,000.00	6,500,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	4,925,000.00	6,500,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	4,925,000.00	6,500,000.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	140,335,493.46	98,721,492.19
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	141,078,900.00	58,388,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	141,078,900.00	58,388,000.00

2200	Дотоод эх үүсвэрээр	141,078,900.00	58,388,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	141,078,900.00	58,388,000.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-141,078,900.00	-58,388,000.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	-743,406.54	40,333,492.19
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,750,166.63	1,006,760.09
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,006,760.09	41,340,252.28

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,347,393,178.65	2,756,005,556.98	471,716,550.11	4,575,115,285.74
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,347,393,178.65	2,756,005,556.98	471,716,550.11	4,575,115,285.74
9	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	1,189,309,094.50	1,189,309,094.50
10	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,347,393,178.65	2,756,005,556.98	1,661,025,644.61	5,764,424,380.24
11	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,347,393,178.65	2,756,005,556.98	1,661,025,644.61	5,764,424,380.24
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,347,393,178.65	2,756,005,556.98	1,661,025,644.61	5,764,424,380.24
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.00	0.00	40,273,902.97	40,273,902.97
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.00	-40,273,902.97	0.00	-40,273,902.97
19	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	1,662,998,701.67	1,662,998,701.67
20	2024 оны 6-р сарын 30-наарх үлдэгдэл	1,347,393,178.65	2,715,731,654.01	3,364,298,249.25	7,427,423,081.91

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Гүйцэтгэл зөрүү /хэтрэлт, хэмнэлт/	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	10,498,962,400.00	9,685,645,420.79	-813,316,979.21	92.25
21	УРСГАЛ ЗАРДАЛ	10,498,962,400.00	9,685,645,420.79	-813,316,979.21	92.25
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	10,492,462,400.00	9,679,145,420.79	-813,316,979.21	92.25

2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	5,900,511,900.00	5,597,836,394.47	-302,675,505.53	94.87
210101	Үндсэн цалин	2,866,689,400.00	2,808,202,641.49	-58,486,758.51	97.96
210102	Нэмэгдэл	2,493,609,300.00	2,255,294,103.07	-238,315,196.93	90.44
210103	Унаа хоолны хөнгөлөлт	204,002,200.00	167,825,885.74	-36,176,314.26	82.27
210104	Урамшуулал	336,211,000.00	366,513,764.17	30,302,764.17	109.01
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	862,074,800.00	690,340,604.54	-171,734,195.46	80.08
210201	Тэтгэврийн даатгал	630,239,400.00	478,568,655.76	-151,670,744.24	75.93
210202	Тэтгэмжийн даатгал	57,958,900.00	55,990,277.66	-1,968,622.34	96.60
210203	ҮОМШӨ-ний даатгал	28,979,400.00	28,979,400.00	0.00	100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	28,979,400.00	15,912,244.51	-13,067,155.49	54.91
210205	Эрүүл мэндийн даатгал	115,917,700.00	110,890,026.61	-5,027,673.39	95.66
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	856,578,200.00	618,906,941.04	-237,671,258.96	72.25
210301	Гэрэл, цахилгаан	131,405,700.00	112,586,737.38	-18,818,962.62	85.68
210302	Түлш, халаалт	552,903,800.00	381,171,761.30	-171,732,038.70	68.94
210303	Цэвэр, бохир ус	172,268,700.00	125,148,442.36	-47,120,257.64	72.65
2104	Хангамж, бараа материалын зардал	174,361,900.00	153,450,891.80	-20,911,008.20	88.01
210401	Бичиг хэрэг	20,292,000.00	15,074,140.00	-5,217,860.00	74.29
210402	Тээвэр, шатахуун	69,500,000.00	58,294,220.00	-11,205,780.00	83.88
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,787,000.00	8,085,281.80	2,298,281.80	139.71
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	5,000,000.00	6,295,000.00	1,295,000.00	125.90
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	73,782,900.00	65,702,250.00	-8,080,650.00	89.05
2105	Нормативт зардал	2,265,764,900.00	2,199,798,321.94	-65,966,578.06	97.09
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,052,822,700.00	1,958,189,821.94	-94,632,878.06	95.39
210502	Хоол, хүнс	210,942,200.00	236,741,000.00	25,798,800.00	112.23
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,000,000.00	4,867,500.00	2,867,500.00	243.38
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	164,262,200.00	167,677,847.00	3,415,647.00	102.08
210601	Багаж, техник, хэрэгсэл	84,700,000.00	87,857,817.00	3,157,817.00	103.73
210602	Тавилга	0.00	1,672,000.00	1,672,000.00	
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,000,000.00	600,000.00	-400,000.00	60.00
210604	Урсгал засвар	78,562,200.00	77,548,030.00	-1,014,170.00	98.71
2107	Томилолт, зочны зардал	8,697,000.00	8,669,240.00	-27,760.00	99.68
210702	Дотоод албан томилолт	8,697,000.00	8,669,240.00	-27,760.00	99.68
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	243,377,500.00	225,798,280.00	-17,579,220.00	92.78
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	227,684,700.00	208,253,390.00	-19,431,310.00	91.47
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	720,000.00	0.00	-720,000.00	0.00
210803	Даатгалын үйлчилгээ	3,243,000.00	3,222,475.00	-20,525.00	99.37
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,790,600.00	1,091,777.00	-698,823.00	60.97

210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	363,000.00	0.00	-363,000.00	0.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	7,770,000.00	7,770,000.00	0.00	100.00
210807	Газрын төлбөр	968,700.00	665,138.00	-303,562.00	68.66
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	837,500.00	4,795,500.00	3,958,000.00	572.60
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	16,834,000.00	16,666,900.00	-167,100.00	99.01
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	16,834,000.00	16,666,900.00	-167,100.00	99.01
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	6,500,000.00	6,500,000.00	0.00	100.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	6,500,000.00	6,500,000.00	0.00	100.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	6,500,000.00	6,500,000.00	0.00	100.00
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	10,497,909,160.09	9,715,078,912.98	-782,830,247.11	92.54
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	807,578,000.00	569,906,884.29	-237,671,115.71	70.57
320001	Орон нутгийн төсвөөс	807,578,000.00	569,906,884.29	-237,671,115.71	70.57
33	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	9,507,545,900.00	8,968,228,768.69	-539,317,131.31	94.33
330002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	9,507,545,900.00	8,968,228,768.69	-539,317,131.31	94.33
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	182,785,260.09	176,943,260.00	-5,842,000.09	96.80
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	176,861,400.00	172,072,548.00	-4,788,852.00	97.29
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,917,100.00	4,870,712.00	-46,388.00	99.06
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	1,006,760.09	0.00	-1,006,760.09	0.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	1,006,760.09	1,006,760.09	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	41,340,252.28	41,340,252.28	
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	0.00	-1.00	0.00
610001	Төсвийн байгууллага	1.00	0.00	-1.00	0.00
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	201.00	0.00	-201.00	0.00
620001	Удирдах ажилтан	1.00	0.00	-1.00	0.00
620002	Гүйцэтгэх ажилтан	136.00	0.00	-136.00	0.00
620003	Үйлчлэх ажилтан	64.00	0.00	-64.00	0.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	201.00	0.00	-201.00	0.00
650008	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)	144.00	0.00	-144.00	0.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	57.00	0.00	-57.00	0.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сэлэнгэ аймгийн Мандал сумын Нэгдсэн эмнэлэг нь 2024 оныг /цаашид Нэгдсэн эмнэлэг гэх/ нь “Нийгмийн эрүүл мэндийг дэмжих” жил болгон зорилго дэвшүүлж, ажилласан байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлон хэрэгжүүлж, ажилласан байна. Үүнд:

- *Жирэмсэн, төрөлт, төрсний дараах үед эх, ураг, нярайд эмнэлгийн мэргэжилтний үзүүлэх эх барихын тусламж, үйлчилгээ;*
- *Хүний амь насанд аюултай өвчин эмгэгийг оношлох, эмчлэх, сэхээн амьдруулах, хүндрэхээс сэргийлэхэд чиглэсэн хойшлуулшгүй үзүүлэх эмнэлгийн яаралтай тусламж;*
- *Гэнэтийн цочмог өвчин эмгэг, осол, гэмтэл, хордлого, жирэмсэн, төрөх, амь тэнссэн үед эмнэлгийн тусламжийг газар дээр нь болон тээвэрлэх явцад үзүүлж, эмнэлэгт хүргэх түргэн тусламжийн үйлчилгээ;*
- *Өвчин эмгэг бүхий үйлчлүүлэгчийг асран сувилах замаар эрүүл мэндийг дэмжихэд чиглэсэн сувилахуйн дагнасан тусламж, үйлчилгээ;*
- *Өвчин эмгэг, бусад хүчин зүйлийн нөлөөгөөр бий болсон хүний биеийн бүтэц, үйл ажиллагааны алдагдлын улмаас үүссэн үр дагаврыг арилгахад чиглэсэн сэргээн засах тусламж, үйлчилгээ үзүүлэх гэх мэт.*

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- *Монгол Улсын 2024 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,*
- *Хөдөлмөрийн тухай хуульд 2024 оны 01 дугаар сарын 12, 06 дугаар сарын 05-нд нэмэлт өөрчлөлт орсон,*
- *Төрийн хэмнэлт тухай хуульд 2024 оны 01 дүгээр сарын 17, 12 дугаар сарын 12-нд нэмэлт өөрчлөлт орсон,*
- *Төрийн албаны тухай хуульд 2024 оны 05 дугаар сарын 16, 06 дугаар сарын 05-нд нэмэлт өөрчлөлт орсон,*
- *Эрүүл мэндийн тухай хуульд 2024 оны 01 дүгээр сарын 12, 17, 06 дугаар сарын 05-нд нэмэлт өөрчлөлт орсон,*
- *Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд 2024 оны 01 дүгээр сарын 12, 06 дугаар сарын 05-нд нэмэлт өөрчлөлт орсон,*
- *Засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 27-ний өдрийн 128 дугаар тогтоолоор төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон,*
- *ЭМДҮЗ-ийн 2024 оны 03 дугаар сарын 29-ний “Жагсаалт, төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах тухай” 06 дугаар тогтоол, 10 дугаар сарын 03-ны “Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” 14 дүгээр тогтоол гэх мэт.*

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ.

Нэгдсэн эмнэлгийн санхүүгийн үйл ажиллагаанд ЭМЯ-ны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар хяналт тавьж, ажилладаг бөгөөд тайлант онд сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээ, шилэн дансны мэдээллээр дамжуулан төсвийн дотоод хяналтыг хэрэгжүүлсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Нэгдсэн эмнэлгийн 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг **аккруэл** сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Нэгдсэн эмнэлгийн даргын 2019 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 175 дугаар тушаалаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг мөрдөн ажиллаж байна.

Уг Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь эрүүл мэндийн салбарын гүйцэтгэлээр санхүүжиж байгаа үйл ажиллагааны онцлог, холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцэхгүй байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Нэгдсэн эмнэлгийн 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан *Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам*”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,076,773.1 мянган төгрөгөөр буюу 16.7 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	1,006.8	41,340.3	40,333.5
Авлага	301,744.5	1,232,836.8	931,092.3
Бараа материал	445,728.0	445,427.9	-300.1
Үндсэн хөрөнгө	5,683,069.1	5,788,716.5	105,647.4

Нийт хөрөнгө	6,431,548.4	7,508,321.5	1,076,773.1
Өр төлбөр	667,124.0	80,898.4	-586,225.6
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	5,764,424.4	7,427,423.1	1,662,998.7
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	6,431,548.4	7,508,321.5	1,076,773.1

Дээрх хүснэгтээс харахад нөлөө бүхий өөрчлөлт гарсан дараах данснууд байна. Үүнд:

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 41,340.3 мянган төгрөг болж 40,333.5 мянган төгрөгөөр өссөн нь үндсэн дансны зардлын хэмнэлтээс шалтгаалсан байна.

Авлага данс 1,232,836.8 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнагдсан нь ЭМДС-аас авах санхүүжилтийн **1,229,706.9** мянган төгрөгийн авлага тайлагнагдсанаас голлон шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 5,788,716.5 мянган төгрөг болж 105,647.4 мянган төгрөгөөр өссөн нь ЭМЯ, аймгийн ЗДТГ, Азийн хөгжлийн банк зэрэг байгууллагуудаас 805,394.0 мянган төгрөгийн хөрөнгө үнэ төлбөргүй авсан, аймгийн ИТХ-ын 2024 оны 153 дугаар тогтоолоор 118,721.8 мянган төгрөгийн хөрөнгийг акталж, устгасан зэргээс голлон шалтгаалсан байна.

Өр төлбөр данс 80,898.4 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнагдаж, өмнөх оноос 586,225.6 мянган төгрөгөөр буурсан нь ЭМДС-ийн 2023 оны санхүүжилтийн дутууг тайлант онд авч, өмнөх онд үүссэн өглөгүүдийг барагдуулснаас шалтгаалсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг ЭМДС-ийн санхүүжилтээс 10,395,062.1 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлогоос 480,686.2 мянган төгрөг, туслах үйл ажиллагааны орлогоос 1,393.2 мянган төгрөг, нийт зардлыг **10,877,141.5** мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналыг 3,988,596.4 мянган төгрөгөөр бууруулж, нийт **6,888,545.1** мянган төгрөгөөр баталсан байна. Үүнд:

- Бараа үйлчилгээний бусад зардлыг 20,000.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж,
- Цалин хөлс болон нэмэгдэл урамшил зардлыг 287,343.7 мянган төгрөгөөр,
- Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардлыг 86,215.8 мянган төгрөгөөр,
- Байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 718,770.7 мянган төгрөгөөр,
- Хангамж бараа материалын зардлыг 63,555.0 мянган төгрөгөөр,
- Нормативт зардлыг 1,246,463.6 мянган төгрөгөөр,
- Эд хогшил, урсгал засварын зардлыг 283,560.7 мянган төгрөгөөр,

- Томилолт, зочны зардлыг 3,538.0 мянган төгрөгөөр,
- Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлыг 645,454.9 мянган төгрөгөөр,
- Бусад урсгал шилжүүлгийн зардлыг 673,694.0 мянган төгрөгөөр зэрэг.

Төсвийн жилийн дундуур батлагдсан төсвийг 3,615,084.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн /цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардлыг 1,158,069.30 мянган төгрөгөөр, НДШ-ийн зардлыг 269,269.4 мянган төгрөгөөр, байр ашиглахтай холбоотой тогтмол зардлыг 794,556.8 мянган төгрөгөөр, нормативт зардлыг 1,081,686.5 мянган төгрөгөөр нэмэгдүүлсэн нь голлон нөлөөлсөн байна/ нийт **10,503,629.1** мянган төгрөгөөр эцэслэн баталсан байна. Үүнд:

- ЭМДС-ийн санхүүжилтээс 9,514,045.9 мянган төгрөг,
- Орон нутгийн төсвөөс 807,578.0 мянган төгрөг,
- Үндсэн үйл ажиллагааны орлогоос 176,861.4 мянган төгрөг
- Туслах үйл ажиллагааны орлогоос 5,143.8 мянган төгрөг гэх мэт.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн гүйцэтгэлээр төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр 9,514,045.9 мянган төгрөгийг ЭМДС-ийн санхүүжилтээс, 807,578.0 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 176,861.4 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос, 5,143.8 мянган төгрөгийг туслах үйл ажиллагааны орлогоос бүрдүүлэхээр төлөвлөн гүйцэтгэлээр ЭМДС-аас 8,968,228.8 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 569,906.9 мянган төгрөгийн санхүүжилт авч, үндсэн үйл ажиллагааны орлогоос 172,072.5 мянган төгрөг, туслах үйл ажиллагааны орлогоор 15,770.7 мянган төгрөг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл **9,685,645.4** мянган төгрөг буюу **92.2** хувьтай тайлагнагдсан байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Үндсэн үйл ажиллагааны зардал	9,384,474.5	8,813,632.9	570,841.6	93.9
2	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал	63,617.3	54,203.3	9,414.0	85.2
3	Нэмэлт - Дээд шатны төсвөөс хуваарилсан	247,959.3	247,902.3	57.0	100.0
4	Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	807,578.0	569,906.9	237,671.1	70.6
	Дүн	10,503,629.1	9,685,645.4	817,983.7	92.2

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Сангийн яамны 2022 оны 02 дугаар сарын 28-ны “Чиглэл хүргүүлэх тухай” албан бичгээр байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансыг хааж, нэмэлт санхүүжилттэй холбоотой гүйлгээг урсгал дансаар дамжуулан гүйцэтгэж, тайланг төсвийн гүйцэтгэлийн тайланд нэгтгэсэн байна.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант онд дараах худалдан авах ажиллагааны урилгыг ТБОНӨХБАҮХАТ хуульд заасны дагуу tender.gov.mn-д цахим сайтад байршуулж, зохион байгуулсан байна. Үүнд:

№	Тухайн жилд худалдан авах бараа, ажил, үйлчилгээний нэр төрөл, тоо, хэмжээ, хүчин чадал	Батлагдсан төсөв	Гэрээний дүн	Худалдан авах ажиллагаанд мөрдөх журам /Тендер шалгаруулалтын арга/
1	Эм, эмнэлгийн хэрэгсэл худалдан авах	536,147.3	458,673.1	НТШ
2	Түргэн тусламжийн автомашины шатахуун, тослох материал нийлүүлэх	30,000.0	0.0	НТШ
3	Хоол хүнсний материал нийлүүлэх	143,883.8	0.0	НТШ
4	Эмнэлгийн цэвэрлэгээний материал нийлүүлэх	58,000.0	0.0	НТШ
	Нийт дүн	768,031.1	458,673.1	

Эм, эмнэлгийн хэрэгсэл худалдан авах тендерийн 35 багцаас 28 багцад Хайтан арвижих ХХК, МЭИК, Азифарма ХХК, Энто ХХК, Тэгш-Анар ХХК, Монос трейд, Монфа трейд ХХК, Айвико ХХК, Агниста фарм ХХК, Мөнхийн тун ХХК, Буянт хишиг үр ХХК, Сүвэн-Уул ХХК, Ихшүүдэргэнэ импорт ХХК зэрэг компаниуд шалгарч гэрээ байгуулан, худалдан авах ажиллагааг гүйцэтгэсэн байна. Эм, эмнэлгийн хэрэгсэл худалдан авах тендерийн 7 багц, хоол хүнсний материал, шатахуун, шатах тослох материал болон цэвэрлэгээний материал нийлүүлэх тендерүүд нь амжилтгүй болсон тул өмнөх онуудад гэрээний үндсэн дээр бэлтгэн нийлүүлэлт хийж байсан Интер Сайнс ХХК, Женру монгол ХХК, Ноцох дөл ХХК, Баян Ундрал Хараа ХХК, Уужимхараа ХХК, Шүүтийн өвөр ХХК, Шунхлайпетролиум ХХК зэрэг байгууллагуудтай гэрээ байгуулан, худалдан авах ажиллагааг гүйцэтгэсэн байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Нэгдсэн эмнэлгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн зардал, санхүүжилт, цалингийн бүртгэлтэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор О.Анхбаяр гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Нэгдсэн эмнэлгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 17 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 8,050,588.7 мянган төгрөгөөс 1 хувиар буюу **80,505.9** мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж үзээд шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж дүгнэсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

“Төрийн хэмнэлтийн тухай хууль”-ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Нэгдсэн эмнэлэг нь дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- *Бичгийн цаас, принтерийн хорны зардлыг хэмнэх зорилгоор бичиг хэрэг, албан хэрэг хөтлөлтөд дотоод сүлжээг ашигласан,*
- *Уран шоргоолж ХХК-с хэрэглээний усны төлбөрийн зардлыг задгайгаар буюу сар бүр 3000000 төгрөг төлдөг байсныг СББ ХХК-иас халаалт, цэвэр усны системийн холболтыг хийснээр усны зардалд сар бүр 140.0-200.0 мянган төгрөгийг төлдөг болсон,*
- *Мөн өөрчлөлт шинэчлэлийг дэмжих ажлыг хэрэгжүүлэх чиглэлээр яаралтай тусламжийн автомашиныг цэнхэр дэвсгэртэй улсын дугаартай болгох ажлыг хийж гүйцэтгэсэн.*

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор

www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд Нэгдсэн эмнэлэг нь мэдээлбэл зохих 29 төрлийн 183 мэдээллийг хугацаанд нь мэдээлсэн байна.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Дарга, тэргүүлэх аудиторын 2024 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 173 дугаар “Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай” албан бичгийг хүргүүлсэн бөгөөд завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг нотлох баримттай тулган баталгаажуулахад 100.0 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	1	6,965.5	1	6,965.5	100.0
Албан шаардлага	1	2,500.0	1	2,500.0	100.0
Зөвлөмж	2		1	0.0	50.0
Нийт дүн	4	9,465.5	3	9,465.5	100.0

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараах асуудлуудыг дээд шатны төсвийн захирагчийн санхүүгийн тайланд хийх аудит болон дараагийн аудитын анхааралд хандуулж байна. Үүнд:

1.Тайлант онд ЭМДЕГ-тай байгуулсан “Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ худалдан авах гэрээ”-ний 2.4.2-т “Төсвийн тухай хуульд заасан санхүүгийн тайлангийн цаглабартай холбогдуулан тухайн төсвийн жилийн 6, 12 дугаар саруудад үзүүлсэн тусламж, үйлчилгээний гүйцэтгэлийг тухайн сарын 10-ны өдрөөр тасалбар болгон хуанлийн 2 хоногт багтаан илгээх, 11-ний өдрөөс тухайн сар дуусталх хугацаанд үзүүлсэн тусламж, үйлчилгээний гүйцэтгэлийг дараа сарын нэхэмжлэлтэй хамтатган хүргүүлэх” гэж заасныг мөрдлөг болгон ЭМДС-аас авах 12 дугаар сарын 11-ээс 31-ийг хүртэлх хугацаанд үзүүлсэн тусламж үйлчилгээний авлага болох **337,587.2** мянган төгрөгийг санхүүгийн тайланд авлагаар тусгаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх “Төсвийн жил нь тухайн оны 1 дүгээр сарын 01-ний өдөр эхэлж, тухайн оны 12 дугаар сарын 31-ний өдөр дуусгавар болно”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ”, 14.4.2: “бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэл хөтлөлттэй холбоотой нийт **27,736.7** мянган төгрөгийн алдаа илэрснээс 10,880.0 мянган төгрөгийн алдааг аудитын явцад залруулж, 16,856.7 мянган төгрөгийн залруулаагүй алдаанд зөвлөмж өглөө. Үүнд:

Залруулсан алдаа:

- Үнэ төлбөргүй ирсэн бараа материалын орлогыг 2,460.0 мянган төгрөгөөр илүү тайлагнасан,
- Тавилга, эд хогшлын дансанд компьютер, принтер зэрэг 8,420.0 мянган төгрөгийн машин, тоног төхөөрөмж бүртгэж, тайлагнасан.

Залруулаагүй алдаа:

- Үндсэн хөрөнгийн тавилга, эд хогшлын дансанд компьютер, принтер зэрэг 15 нэр төрлийн 16,856.7 мянган төгрөгийн тоног төхөөрөмж бүртгэж, бүртгэл тайланд тусгасан байна.

Эдгээр нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйл: “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална.” 5.1.4 дэх “Үнэн зөв байх” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийг холбогдох хууль, эрх зүйн актад нийцүүлэн үнэн зөв бүртгэх, залруулаагүй алдааг 2025 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд залруулга хийх.

Аудитаар **36,015.7** мянган төгрөгийн зөрчил¹ илэрч 3,354.8 мянган төгрөгийн төлбөрийн акт, 32,660.9 мянган төгрөгийн албан шаардлага, 3 зөвлөмж хүргүүлсэн.

5.1 Төлбөрийн акт

1.Тус байгууллагын 19 албан хаагчдыг ажлын бус цагаар дуудаж ажиллуулсан /тайлан, мэдээ, албан бичиг, хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулсан, хариу хүргүүлсэн, судалгаа хийсэн, хурал, сургалтад хамрагдсан, хяналт тавьсан, засвар хийсэн г.м/ гэх үндэслэлээр илүү цагийн нэмэгдлийг тухайн сарын ажлын цагийн 10 хувиас хэтрүүлэн **3,354.8** мянган төгрөг илүү олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид нэмэгдэл хөлс олгох журам”-ын 3 дугаар зүйлийн 3 дахь “Илүү цагаар, долоо хоногийн амралтын өдрөөр, нийтээр амрах баяр ёслолын өдрөөр, шөнийн цагаар ажилласны нэмэгдэл хөлс тооцох цаг нь 4.1-т зааснаас бусад тохиолдолд тухайн сарын ажлын цагийн **10** хувиас хэтрэхгүй байна” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Шийдвэрлэлт: Илүү тооцож, олгосон илүү цагийн хөлсийг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоох.

5.2 Албан шаардлага

1. Батлагдсан төсвийг зориулалт бусаар, зардлын бүлэг хооронд гүйлгэн зарцуулж, бодитоор тайлагнаагүй **32,660.9** мянган төгрөгийн зөрчил илэрсэн нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д “*Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах*”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “*Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно*” гэж заасныг болон Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах зааврын”-ыг тус тус зөрчсөн байна. Үүнд:

- Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлсийн зардлаас тавилга, эд хогшил худалдан авахад 6,220.0 мянган төгрөг, бага үнэтэй бус бараа материал худалдан авах зардалд 6,030.0 мянган төгрөг зэрэг нийт 12,250 мянган төгрөг,
- Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгслийн зардлаас багаж, техник хэрэгслийн зардалд 3,500.0 мянган төгрөг,
- Мэдээлэл технологийн үйлчилгээний зардлаас урсгал засварын зардалд 2,000.0 мянган төгрөг, шуудан, холбооны зардалд 1,160.0 мянган төгрөг зэрэг нийт 3,160.0 мянган төгрөг,
- Бараа үйлчилгээний бусад зардлаас урсгал засварын зардалд 13,541.9 мянган төгрөг, шуудан холбооны зардалд 209.0 мянган төгрөг зэрэг нийт 13,750.9 мянган төгрөг гэх мэт.

Шийдвэрлэлт: Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж байх албан шаардлага хүргүүлэв.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Зардлын бүртгэлтэй холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт: Нийт албан хаагчдын цалингаас 4, 5 дугаар саруудад суутгал хийж “Мандал түмний хишиг” НҮТББ-ын дансанд шилжүүлсэн байна. Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 119 дүгээр зүйлийн 119.1 дэх “*Ажил олгогч ажилтны цалин хөлсийг бүрэн хэмжээгээр нь олгох бөгөөд дараах тохиолдолд суутгал хийж болно:*” гэсэн заалттай нийцэхгүй байна.

1.2 Өгсөн зөвлөмж: Ажилчдын цалингаас зөвхөн хуульд заасан суутгалыг хийж байх.

2. Санхүүжилттэй холбоотой асуудал

2.1 Илрүүлэлт: Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2022 оны 12 дугаар тогтоолоор батлагдсан “*Чанар, төлбөрийн хяналтын журам*”-ын шалгуурыг хангаагүй тул ЭМДС-аас нэхэмжилсэн эмнэлгийн тусламж, үйлчилгээний

санхүүжилт нь эх олонлогийн, системийн, эмч, байцаагчийн гэсэн 4 төрлөөр 766,354,053.0 мянган төгрөгөөр хасагдсан байна.

2.2 Өгсөн зөвлөмж: Сар бүр нэхэмжлэхийн хяналтаар хасагдсан тусламж, үйлчилгээний санхүүжилтэд дүн шинжилгээ хийж, дотоод хяналтыг хэрэгжүүлэх замаар тусламж, үйлчилгээний орлогын бүрэн төвлөрүүлэх.

3. Цалингийн зардалтай холбоотой асуудал

3.1 Илрүүлэлт: Ээлжээр ажилладаг жижүүр, сувилагч зэрэг албан хаагчдын илүү цагийн тооцоолол /*долоо хоногийн амралтын болон нийтээр амрах баярын өдрийн I-ыг зөрүүтэй тооцох, түүнд тавих хяналт сул байгаа нь төсвийн ачааллыг нэмэгдүүлж өр төлбөр үүсэх эрсдэлийг үүсгэж байна. Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 109 дүгээр зүйлийн 109.9 дэх “Ээлжээр ажилладаг ажилтны ээлж долоо хоногийн амралтын болон нийтээр амрах баярын өдөр таарсан бол энэ хуулийн 109.2, 109.4-т заасан нэмэгдэл хөлс олгохгүй ...”, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид нэмэгдэл хөлс олгох журам”-ын 2 дугаар зүйлийн 5 дахь “Албан хаагчийг ээлжийн хуваарийн дагуу шөнийн цагт ажиллуулбал шөнийн цагийн нэмэгдэл хөлсийг олгоно. Ээлжээр ажилладаг албан хаагчийн ээлж долоо хоногийн амралтын болон нийтээр амрах баярын өдөр таарсан бол долоо хоногийн амралтын болон нийтээр амрах баярын өдрөөр ажилласны нэмэгдэл хөлс олгохгүй” гэж заасныг тус тус зөрчсөн байна.*

2.2 Өгсөн зөвлөмж: Ээлжээр ажилладаг ажилчдад амралтын өдрийн болон нийтээр амрах баярын өдрөөр ажилласны нэмэгдлийг тооцож олгохгүй байх, төсвийн зарцуулалтад бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах.

Дээрх зөвлөмжүүдийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20.5² дахь заалтад тусгасны дагуу аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор тус тус төрийн аудитын байгууллагад ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

² Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Үнэ төлбөргүй ирсэн бараа материалын орлогыг 2,460.0 мянган төгрөгөөр илүү тайлагнасан	1	2,460.0			1	2,460.0	1	2,460.0				
Тавилга, эд хогшлын дансанд машин, тоног төхөөрөмж бүртгэсэн	2	25,276.7			2	25,276.7	1	8,420.0	1	16,856.7	1	16,856.7
Дүн	3	27,736.7			3	27,736.7	2	10,880.0	1	16,856.7	1	16,856.7

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Илүү цагийн нэмэгдлийг илүү олгосон	1	3,354.8	1	3,354.8								
Төсвийг зориулалт бусаар зарцуулсан	1	32,660.9			1	32,660.9						
Цалингаас хуульд заагдаагүй суутгал суутгасан	1						1					
ЭМДС-аас нэхэмжилсэн эмнэлгийн тусламж, үйлчилгээний санхүүжилт хасагдсан	1						1					
Ээлжийн албан хаагчдын илүү цагийн хөлсийг зөрүүтэй тооцсон, бүртгэлээр тавих хяналт хангалтгүй	1						1					
Дүн	5	36,015.7	1	3,354.8	1	32,660.9	3					

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн